



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Замын-Үүдийн Дулааны станц” ТӨҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2025/01/НА-СТА-ТӨҮГ

Цахим хуудас: www.audit.mn Дорноговь аймаг 2025 он	Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий Утас: 70522734 Аудитын менежер: У.Оюунтүлхүүр Утас: 70523020 Ахлах аудитор: О.Нарангарав Аудитор: М.Дүүрэнжаргал	Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn Цахим хаяг: narangeravo@audit.gov.mn Цахим хаяг: duurenjargalm@audit.gov.mn
---	---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (976) 7052 2734

Цахим хуудас: dornogovi@audit.gov.mn

2025.03.14 № 1-6/292.

танай _____-ны № _____-т

“ЗАМЫН-ҮҮДИЙН ДУЛААНЫ
СТАНЦ” ТӨҮГ-ЫН ЗАХИРАЛ
О.ТӨМӨРХУЯГ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Замын-Үүдийн Дулааны станц” ТӨҮГ-ын оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус газрын санхүүгийн үндсэн үзүүлэлт нь болох нийт орлого төлөвлөгөөнөөс 83.7 сая төгрөгөөр буюу 1.2 хувиар давж, нийт зардал 393.3 сая төгрөгөөр буюу 3.5 хувиар хэмнэгдсэн гүйцэтгэлтэй, нийт алдагдал 559.1 сая төгрөгөөр багассан зэрэг нь тайлант оны дэвшүүлсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтод түвшинд хүрч ажилласан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

1. Шинэ жилийн баярыг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбоотойгоор албан хаагчдад 6.9 сая төгрөгөөр бэлэг, 2.1 сая төгрөгийг шагналыг тус тус олгож нийт 9.0 сая төгрөгийг зарцуулсан байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т “... төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд нь хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгохыг хориглоно”, 15.1.5 “... төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд нь ... байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

2. Тайлант онд сахилгын шийтгэл ногдуулсан, хугацаа дуусаагүй 2 ажилтанд 0.6 сая төгрөгийн сарын үр дүнгийн урамшууллыг олгосон байна. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.8-т “Хөдөлмөрийн сахилгын шийтгэл ногдуулснаас хойш нэг жил өнгөрөөл ажилтныг хөдөлмөрийн сахилгын шийтгэлгүйд тооцно”,

442502046

“Замын-Үүдийн Дулааны станц” ТӨҮГ-ын 2022 оны А/141 дүгээр тушаалаар батлагдсан “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 8 дугаар зүйлийн 8.7.2-т “сахилгын шийтгэл ногдуулсан ажилтны тухайн сарын урамшуулал цалинг олгохгүй” гэж заасантай нийцэхгүй байна.

3. Албан хаагчдын ээлжийн амралтын тооцоог шалгахад ажлын цагийн тооцоог буруу гаргаж өгснөөс шалтгаалан нийт 10 албан хаагчид 4.2 сая төгрөгийн цалинг давхардуулан олгосон байна. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.3-т “гүйцэтгэсэн ажил үүрэгтээ тохирсон цалин хөлс авах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасантай нийцэхгүй байна.

4. Албан хаагчдын ээлжийн амралтын тооцоог шалгахад 7 албан хаагчдад тайлант оны ээлжийн амралтын тооцоог дуусгаагүй байна. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.4-т “ээлжийн амралт эдлэх, зохих журмын дагуу хувийн чөлөө авах”, 99 дүгээр зүйлийн 99.1-т “Ажилтанд ажлын жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ. Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд олгох мөнгөн урамшууллын хэмжээг энэ хуулийн 110.2-т заасан хэмжээнээс нэмэгдүүлж олгох асуудлыг хамтын гэрээгээр, хамтын гэрээгүй бол ажилтантай тохиролцон олгоно”, 110 дугаар зүйлийн 110.2-т “Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд ээлжийн амралтын цалинг нэг аравны тав дахин нэмэгдүүлж олгоно”, “Замын-Үүдийн Дулааны станц” ТӨҮГ-ын 2022 оны А/141 дүгээр тушаалаар батлагдсан “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 7.3.7-т “ээлжийн амралттай ажилтанг ажлын зайлшгүй шаардлагаар ажилд нь дуудан оруулсан тохиолдолд ажилтны саналаар амралтыг нь эдлүүлэх хугацааг тохирч нөхөн амраах, эсвэл хуульд заасан хэмжээгээр олговор олгох” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.ГАН-ӨЛЗИЙ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	Үлдэгдэл	
		1 сарын 1	12 сарын 31
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	202,374,495.32	43,341,048.61
1.1.02	Дансны авлага	531,340,254.73	236,257,372.59
1.1.03	Татвар, НДШ-ийн авлага	9,938,206.60	10,010,000.00
1.1.04	Бусад авлага	66,311,448.49	60,116,588.00
1.1.06	Бараа материал	937,059,358.88	1,116,941,890.61
1.1.07	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	26,276,246.08	12,425,199.25
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,773,300,010.10	1,479,092,099.06
1.2.01	Үндсэн хөрөнгө	70,117,562,848.03	77,205,849,831.29
1.2.02	Биет бус хөрөнгө	20,728,189.40	12,901,322.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	70,138,291,037.43	77,218,751,153.29
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	71,911,591,047.53	78,697,843,252.35
2.1.1.01	Дансны өглөг	574,476,489.49	850,430,445.33
2.1.1.03	Татварын өр	72,925,364.22	310,502,693.37
2.1.1.08	Урьдчилж орсон орлого	35,833,646.28	17,355,620.27
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	3,626,129.37	830,390.18
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	686,861,629.36	1,179,119,149.15
2.1.2.04	Бусад урт хугацаат өр төлбөр	0.00	8,749,865,392.72
2.1.2.06	Урт хугацаат өр төлбөрийн дүн	0.00	8,749,865,392.72
2.2	Өр төлбөрийн нийт дүн	686,861,629.36	9,928,984,541.87
2.3.01	Өмч: - төрийн	75,567,469,417.78	75,567,469,417.78
2.3.06	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	106,632,845.92	106,632,845.92
2.3.09	Хуримтлагдсан ашиг	(4,449,372,845.53)	(6,905,243,553.22)
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг	0.00	(2,452,455,577.51)
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	(4,449,372,845.53)	(4,452,787,975.71)
2.3.11	Эздийн өмчийн дүн	71,224,729,418.17	68,768,858,710.48
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	71,911,591,047.53	78,697,843,252.35

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
01	Борлуулалтын орлого (цэвэр)	6,252,154,129.49	7,355,462,512.08
02	Борлуулалтын өртөг	8,227,102,073.95	9,138,370,125.69
03	Нийт ашиг(алдагдал)	(1,974,947,944.46)	(1,782,907,613.61)
04	Түрээсийн орлого	1,070,435.00	0.00
05	Хүүний орлого	6,933,177.06	690,239.27
08	Бусад орлого	252,768.88	1,024,095,726.10
08.1	Орлогын дүн	8,256,380.94	1,024,785,965.37
10	Ерөнхий ба удирдлагын зардал	1,294,341,389.21	1,695,548,905.36
11	Санхүүгийн зардал	434,500.00	616,000.00
12	Бусад зардал	44,971,585.29	0.00
12.1	Зардлын дүн	1,339,747,474.50	1,696,164,905.36
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	1,900,000.00
17.1	Олз, гарзын дүн	0.00	1,900,000.00
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	(3,306,439,038.02)	(2,452,386,553.60)
19	Орлогын татварын зардал	693,317.70	69,023.91
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(3,307,132,355.72)	(2,452,455,577.51)
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(3,307,132,355.72)	(2,452,455,577.51)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Хөр-н дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
01	2022 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	75,256,227,787.78	19,112,120.17	(1,171,965,580.42)	74,103,374,327.53
02	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	29,725,090.61	29,725,090.61
03	Залруулсан үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
04	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	(3,307,132,355.72)	(3,307,132,355.72)
05	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00
06	Өмчид гарсан өөрчлөлт	311,241,630.00	0.00	0.00	311,241,630.00
07	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
08	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	87,520,725.75	0.00	87,520,725.75
09	2023 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	75,567,469,417.78	106,632,845.92	(4,449,372,845.53)	71,224,729,418.17
10	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	(3,415,130.18)	(3,415,130.18)
11	Залруулсан үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	(2,452,455,577.51)	(2,452,455,577.51)
13	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00
14	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
15	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	0.00
17	2024 оны 12 сарын 31-р үлдэгдэл	75,567,469,417.78	106,632,845.92	(6,905,243,553.22)	68,768,858,710.48

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	6,864,722,108.88	9,384,666,568.89
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	6,764,399,034.15	8,201,656,692.17
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	0.00	1,000,000,000.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	100,323,074.73	183,009,876.72
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	7,605,747,496.63	9,210,564,350.12
1.2.1	Ажиллагчдад төлсөн	2,970,684,495.14	3,691,993,802.58
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	923,679,711.24	1,227,564,708.42
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	1,516,124,922.60	2,177,322,446.77
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	663,160,099.58	748,633,913.10
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	379,534,740.78	235,014,090.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	842,189,227.62	796,234,324.53
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	3,909,311.00	3,676,836.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	306,464,988.67	330,124,228.72
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(741,025,387.75)	174,102,218.77
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	0.00	1,900,000.00
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	0.00	1,900,000.00
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	224,120,145.00	335,035,665.48
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	224,120,145.00	335,035,665.48
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(224,120,145.00)	(333,135,665.48)
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(965,145,532.75)	(159,033,446.71)
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,167,520,028.07	202,374,495.32
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	202,374,495.32	43,341,048.61

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт			
	а) Дулаан үйлдвэрлэлт /Гкал/	67,800.00	65,910.00	1,890.00
	б) Ус хангамж /м3/	322,700.00	337,850.00	(15,150.00)
	в) Ариутгах татуурга /м3/	260,200.00	283,580.00	(23,380.00)
	Нийт орлого	7,305,389,400.00	7,389,119,538.00	(83,730,138.00)
	Үүнээс: Цэвэр борлуулалт	6,835,389,400.00	6,760,343,120.00	75,046,280.00
2	Нийт зардал	11,226,025,500.00	10,832,704,045.00	393,321,455.00
	а) Дулаан үйлдвэрлэлт	5,641,891,590.00	5,591,437,940.00	50,453,650.00
	б) Ус хангамж	732,471,060.00	740,829,310.00	(8,358,250.00)
	в) Ариутгах татуурга	461,026,750.00	428,075,870.00	32,950,880.00
	Бусад орлого /алданги торгууль, засвар үйлчилгээ/	470,000,000.00	628,776,418.00	(158,776,418.00)
3	Нийт зардал	11,226,025,500.00	10,832,704,045.00	393,321,455.00
3.1	Үүнээс: Удирдлагын зардал	318,823,000.00	300,176,780.00	18,646,220.00
	а) Дулаан үйлдвэрлэлт	8,082,738,360.00	7,724,385,876.00	358,352,484.00
	б) Ус хангамж	1,347,123,060.00	1,021,803,870.00	325,319,190.00
	в) Ариутгах татуурга	1,796,164,080.00	1,786,337,510.00	9,826,570.00
4	Татварын өмнөх ашиг /алдагдал	(3,920,636,100.00)	(3,443,584,507.00)	(477,051,593.00)
	Улсын төсвийн татаас	909,090,000.00	909,090,909.00	(909.00)
5	Тооллогоор бүртгэсэн бараа материал	-	82,038,020.49	
6	Цэвэр ашиг /алдагдал/	(3,011,546,100.00)	(2,452,455,577.51)	(559,090,522.49)
7	Төсвийн төлбөр	1,832,745,100.00	2,528,330,500.00	(695,585,400.00)
7.1	Аж ахуй нэгжийн орлогын албан татвар	-	-	-
7.2	Нэмэгдсэн өртгийн албан татвар	740,920,900.00	826,589,200.00	(85,668,300.00)
7.3	Ус ашигласны төлбөр	6,400,000.00	9,261,700.00	(2,861,700.00)

Замын-Үүдийн Дулааны станц ТӨҮГ 2024 оны санхүүгийн тайланд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

7.4	Газрын төлбөр	4,000,000.00	3,404,000.00	596,000.00
7.5	Агаарын бохирдлын төлбөр	3,143,600.00	3,143,600.00	-
7.6	Тээврийн хэрэгслийн татвар	1,000,000.00	1,000,000.00	-
7.7	Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын шимтгэл	674,359,800.00	1,144,399,500.00	(470,039,700.00)
7.8	Үл хөдлөх хөрөнгийн татвар	162,957,400.00	155,146,200.00	7,811,200.00
7.9	ХХОАТ	302,305,400.00	385,314,500.00	(83,009,100.00)
7.10	Бусад	37,658,000.00	71,800.00	37,586,200.00
8	Төрийн өмчийн ногдол ашиг	-	-	-
9	Ажиллагсдын тоо	146.00	141.00	5.00
10	Нийт цалингийн сан	4,125,956,100.00	4,122,102,510.00	3,853,590.00
11	Нэг ажилтны сарын дундаж цалин	2,354,997.77	2,436,230.80	(81,233.02)
12	Борлуулалтын орлогын 1 төгрөгт ногдох зардал	1.53	1.53	1.53
13	Хөрөнгө оруулалт	570,499,000.00	407,965,500.00	162,533,500.00
14	Нийт авлага	236,906,000.00	306,383,960.00	(69,477,960.00)
15	Нийт өглөг	-	1,179,119,149.00	(1,179,119,149.00)
15.1	Үүнээс: богино хугацаат өр төлбөрт	-	1,179,119,149.00	(1,179,119,149.00)
15.2	Урт хугацаат өр төлбөрт	-	-	-

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу 2024 онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан, тодотгол оруулан, тайлагнаж ажилласан байна. Нийт 33 худалдан авах ажиллагааны 3 нь нээлттэй тендер шалгаруулалт, 9 нь харьцуулалтын арга, 21 нь шууд худалдан авалтын аргаар зохион байгуулагдахаар төлөвлөгдөж, гүйцэтгэлээр нээлттэй тендер шалгаруулалтаар 3, харьцуулалтын аргаар 4, шууд худалдан авалтын аргаар 16 ХАА зохион байгуулж, бэлтгэн нийлүүлэгчтэй гэрээг байгуулан, хэрэгжилтийг хангуулан ажиллаж, тайланг цахим системээр хүргүүлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд нийцсэн байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тайлант оны эхний 9 сарын санхүүгийн тайлан, баримтад завсрын аудитыг хийн, санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдийг буруу илэрхийлсэн байх, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй, бүрэн хөтлөөгүй байх, авлага, өглөгийн үлдэгдлийг харилцагч болон бэлтгэн нийлүүлэгч этгээдтэй тооцоо нийлсэн нийлж, баталгаажуулаагүй байх, насжилттай авлагыг бууруулах арга хэмжээ зохион байгуулаагүй байх, худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулаагүй байх, үндсэн хөрөнгийг бүртгэлд тусгаагүй байх зэрэг 7 горим сорилыг хэрэгжүүлж төлөвлөгөө хөтөлбөрийг батлуулсан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 3 зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	3	-	3	-	100%
Нийт дүн	3	-	3	-	100%

/мянган төгрөгөөр/

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

“Замын-Үүдийн Дулааны станц”-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөрх санхүүгийн тайлангийн эргэлтийн бус хөрөнгөд ус цэвэршүүлэх үйлдвэртэй холбоотой ашиглагддаггүй 14,435.5 сая төгрөгийн хөрөнгө үр ашиггүйгээр бүртгэлд тусгагдан, хадгалагдаж байна. Тухайн хөрөнгийг ТӨБЗГ-ын 2021 оны 405 дугаар тогтоолоор тухайн байгууллагад Барилга хот байгуулалтын яамны харьяа Дэд бүтцийн ашиглалтын өмнөх захиргааны газраас балансаас балансад шилжүүлэн өгч, хүлээж авснаас хойш огт ашиглагдаагүй байна. Тухайлбал: тухайн хөрөнгөд 1 ширхэг нь 66.7 сая төгрөгийн үнэтэй 2 ширхэг албан тасалгааны агааржуулагч бүртгэлтэй байна.

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 8,860.8 сая төгрөгийн 5 алдаа зөрчил илрүүлснээс 8,843.1 сая төгрөгийн 1 алдааг залруулан, залруулагдаагүй 17.7 сая төгрөгийн 5 зөрчилд 4.7 сая төгрөгийн 2 төлбөрийн акт, 9.0 сая төгрөгийн 1 албан шаардлага, 4.0 сая төгрөгийн 1 зөвлөмж хүргүүлсэн.

Аудитын явцад залруулсан алдаа:

1. Санхүүгийн тайлангуудыг тулган баталгаажуулахад НББ-тэй холбоотой нийт 8,843.1 сая төгрөгийн дараах алдаа гарлаа. Үүнд:

- ТӨБЗГ-ын шийдвэрээр үнэгүй нэмэгдсэн 8,749.9 сая төгрөгийн цэвэр үндсэн хөрөнгө, тооллогоор илэрсэн 82.0 сая.төгрөгийн бараа материал зэргийг бүтгэлд тусгахдаа Эздийн өмчийн төрийн өмчийг нэмэгдүүлсэн,
- Авлагын үлдэгдэлд ажиллагчидтай холбоотой 10.9 сая төгрөгийн, бусад авлагатай холбоотой 0.4 сая төгрөгийн хасаг үлдэгдэлтэй авлага тайлагнагдсан зэрэг алдааг аудитын явцад залруулав.

3.1. Төлбөрийн акт

1. Тайлант онд сахилгын шийтгэл ногдуулсан, хугацаа дуусаагүй 2 ажилтанд 0.6 сая төгрөгийн сарын үр дүнгийн урамшууллыг олгосон байна.
2. Албан хаагчдын ээлжийн амралтын тооцоог шалгахад ажлын цагийн тооцоог буруу гаргаж өгснөөс шалтгаалан нийт 10 албан хаагчид 4.2 сая төгрөгийн цалинг давхардуулан олгосон байна.

3.2. Албан шаардлага

1. Шинэ жилийн баярыг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбоотойгоор албан хаагчдад 6.9 сая төгрөгөөр бэлэг, 2.1 сая төгрөгийг шагналыг тус тус олгож нийт 9.0 сая төгрөгийг зарцуулсан байна.

3.3. Зөвлөмж

1. Цалин хөлстэй холбоотой асуудал:

Илрүүлэлт: Албан хаагчдын ээлжийн амралтын тооцоог шалгахад 7 албан хаагчдад тайлант оны ээлжийн амралтын тооцоог дуусгаагүй байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.4-т “*ээлжийн амралт эдлэх, зохих журмын дагуу хувийн чөлөө авах*”, 99 дүгээр зүйлийн 99.1-т “*Ажилтанд ажлын жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ. Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд олгох мөнгөн урамшууллын хэмжээг энэ хуулийн 110.2-т заасан хэмжээнээс нэмэгдүүлж олгох асуудлыг хамтын гэрээгээр, хамтын гэрээгүй бол ажилтантай тохиролцон олгоно*”, 110 дугаар зүйлийн 110.2-т “*Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд ээлжийн амралтын цалинг нэг аравны тав дахин нэмэгдүүлж олгоно*”, “Замын-Үүдийн Дулааны станц” ТӨҮГ-ын 2022 оны А/141 дүгээр тушаалаар батлагдсан “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 7.3.7-т “*ээлжийн амралттай ажилтанг ажлын зайлшгүй шаардлагаар ажилд нь дуудан оруулсан тохиолдолд ажилтны саналаар амралтыг нь эдлүүлэх хугацааг тохирч нөхөн амраах, эсвэл хуульд заасан хэмжээгээр олговор олгох*” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Тайлант хугацаанд албан хаагчдын ээлжийн амралтыг бүрэн эдлүүлэх, эдлүүлээгүй тохиолдолд ногдох урамшууллыг олгох

Дээрх шийдвэрүүдийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2024 оны 08 дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох
ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруул аагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төрийн өмчийн нэмэгдүүлсэн, хасах үлдэгдэлтэй авлага бүртгэсэн	1	8,843,129.1			1	8,843,129.1	1	8,843,129.1				
Дүн	1	8,843,129.1	-	-	1	8,843,129.1	1	8,843,129.1	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Сахилгын шийтгэлийн хугацаанд урамшуулал олгосон	1	568.4	1	568.4								
Ээлжийн амралтын олговортой цалин давхардуулан олгосон	1	4,157.8	1	4,157.8								
Байгууллагын төсвөөр бэлэг, согтууруулах зүйл авсан	1	8,989.8			1	8,989.8						
ээлжийн амралтын тооцоог дуусгаагүй	1	3,984.6					1	3,984.6				
Дүн	4	17,700.7	2	4,726.2	1	8,989.8	1	3,984.6	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
							Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
	-	-	-	-	-	-	-	-
Дүн	-	-	-	-	-	-	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
	-	-	-	-	-	-	-	-
Дүн	-	-	-	-	-	-	-	-
Нийт дүн	-	-	-	-	-	-	-	-